



БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГазрын дарга: Ц.Наранчимэг
Утас:261663

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885

Ахлах аудитор: Ш.Ичинхорлоо
Утас: 261740


Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын |Ү байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Юнистар” Аудит ХХК
Захирал: М.Энхжаргал
Утас:99168961 328735
Цахим хаяг:
unistar_audit@yahoo.com
Аудитор:М. Энхжаргал
Утас:99168961

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

2018 оны 3 дугаар сар

САГ-2018/84/НӨА-ТӨҮГ



АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.14 № 06/670
танай _____-ны № _____-т

БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Э.ДАШРАВЖИР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0314SAG6.Docx

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
078328
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Багануур ТӨААТҮГ-ын захирал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. M.* Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0314SAG6 Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Багануур тоосго ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийлээ. /САГ-2018/84/СТА-ТӨҮГ/

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын болон ШШГЕГ-аас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.


Багануур тоосго ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-наас 2017 оны 03 дугаар сарын 14-ний хооронд хийхээр төлөвлөн “Юнистар Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Багануур тоосго ТӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 01-нд 3/05 тоот албан бичгээр Юнистар Аудит ХХК-д ирүүлсэн.

“Юнистар Аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 15-наас 2018 оны 03 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд Багануур тоосго ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Багануур тоосго ТӨААТҮГ-ын удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн аудитын тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон эдгээртэй нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн, Сангийн сайдын болон ШШГЕГ-ын тушаал бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.



3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Багануур тоосго ТӨААТҮГ нь ШШГЕГ-аас олгосон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг, хоригдлыг ажлын байраар хангаж төрөл бүрийн барилгын материал үйлдвэрлэн, газар тариалан, мал аж ахуй эрхэлж зах зээлд болон ерөнхий газрын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжид бүтээгдэхүүн нийлүүлэх чиг үүрэг бүхий төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн гэж дүрмэндээ заасан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана...” гэж заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын захирал батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Багануур тоосго ТӨААТҮГ нь өөрийн явуулж буй үйлдвэрлэлийн болон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоороо санхүүждэг

Багануур тоосго ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 31 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ШШГЕГ-ын даргын 2014 оны 12 дүгээр сарын 22-ны өдрийн А/194 тоот тушаалаар батлагдсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагаанд тохируулан мөрдөж байна. Тус газар нь UNICUS програмаар санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Багануур тоосго ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлан бэлтгэх, **ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ**

5. Материаллаг байдал:

Бид санхүүгийн тайланд материаллаг байдлыг авч үзэхдээ материаллаг байдлын суурийг нийт зарлагаас тооцов. Төсвийн нийт зарлагын хэмжээ байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлно гэж үзээд материаллаг түвшинг нийт зарлагын 1 хувиар буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт хэмжээг 1,768.8 сая төгрөгөөр тооцоолов. /ТАБ-СТА-В-1/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Багануур тоосго ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянах явцад дотоод хяналтын талаарх бодлого, дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт байхгүй, нэгж бүтцийн талаарх мэдээлэл байхгүй түүний дотор санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул ажиллаж байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Багануур тоосго ТӨААТҮГ нь ШШГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан төлөвлөгөөт хуваарийн дагуу гүйцэтгэлийг хангах, зоритот түвшингийн зардлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Багануур тоосго ТӨААТҮГ нь 2017 онд 201.0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 111.9 сая төгрөгийн борлуулсан барааны өртөгтэй, 40.3 сая төгрөгийн удирдлагын зардалтай ажиллаж 78.8 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай гарна гэж төлөвлөсөн байна. Харин гүйцэтгэлээр 174.2 сая төгрөгийн орлоготой, 147.6 сая төгрөгийн борлуулсан барааны өртөгтэй 29.3 сая төгрөгийн удирдлагын зардалтай ажиллаж ШШГЕГ-т 69.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Багануур тоосго ТӨААТҮГ нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу 2017 онд 97.5 сая төгрөгийн 96 ширхэг мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудас болон Хууль зүй, дотоод хэргийн, Сангийн яамны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаанд тайлан мэдээг илгээж ажилласан байна. Үүнд тендерт оролцсон мэдээллийн тухай 12 удаа, 5 саяас дээш худалдан авалтын талаар 12 удаа, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлого, зардлыг 11 удаа, бусад мэдээллийг 36 удаа цахим хуудаст оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:



Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 дансанд эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан 31 горим, сорилыг гүйцэтгэв. Аудитын төлөвлөлтийн явцад уламжлалт болон хяналтын эрсдэлүүдийг тооцоход санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаж ажилласан байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлогууд, цалин хөлс болон түлш халаалт, гэрэл цахилгаан зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны эхэнд нийт 24.6 сая төгрөгийн авлагатай байсан. Тус байгууллага нь өмнөх оны үлдэгдэл авлагаа барагдуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст нийт 22.2 сая төгрөгийн авлага үүссэн. Энэ нь Квом ХХК-тай тооцох авлага 7.8 сая төгрөг, Хан баян ХХК-тай холбоотой авлага 14.4 сая төгрөгийн авлага тус тус үүссэн байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.


Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Тус байгууллагад бэлэн мөнгөний кассын болон эд хөрөнгийн нярав байдаггүй. Нягтлан бодогч бэлэн мөнгөөр гүйлгээ хийж, анхан шатны баримтаар нягтлан бодох

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Ажил үүргийн хуваарийг тусгаарлах тухай зөвлөмж өгөх

Тус үйлдвэрийн газар борлуулсан бүтээгдэхүүний өртгийг цех тасгууд дээр хуримтлуулан бүртгэдэг боловч үйлдвэрлэж буй нэгж бүтээгдэхүүн тус бүр дээр нарийн тооцож гаргаагүй байна.



Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжийн өртгийг зүй зохистой тодорхойлж чадахгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүтээгдэхүүний нэгж өртгийг нарийвчлан тооцож байх тухай зөвлөмж өгөх

Тус үйлдвэрийн газар ШШГЕГ-т төвлөрүүлэн шилжүүлсэн 69.9 сая төгрөгийг тайлант жилийн үйл ажиллагааны бус зардлаар бүртгэж, тайлант жилийн алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь НББОУС-1-ийн 104-д “Аж ахуйн нэгж зардлыг чиг үүргээр нь ангилдаг бол...”, Сангийн сайдын 2014 оны 12 сарын 23-ны 249 тоот тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 6 дугаар бүлэгт “Зардал гэдэг нь тухайн тайлангийн хугацааны туршид байгууллагын үндсэн болон бусад үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотойгоор хөрөнгө буурах, өөр ямар нэг байдлаар ашиглагдах, эсвэл өр төлбөр нэмэгдэх байдлаар эдийн засгийн үр дүнг хорогдуулах ажил гүйлгээ үүсэх явдал юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зохих байгууллагатай зөвшилцөн ногдол ашгаар бүртгэж байх тухай зөвлөмж өгөх

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Тайлант жил аудитаар залруулагдаагүй алдаа зөрчил байхгүй.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:


Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 төрлийн зөвлөмж өгч, илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байхыг зөвлөв.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд Ньюбаланс Аудит ХХК-аас хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.



17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежементийн захидал, асуулгын бүртгэл, байгууллагын санхүүгийн тайлан болон судалгаа, саналын хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ, АУДИТОР
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

М. ЭНХЖАРГАЛ
Т. ЭНХТУЯА





**БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар12

Асуудал 2

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн талаар.....13

Асуудал 3

Төвлөрүүлсэн шилжүүлгийн талаар.....14



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хяналт хийсэн бөгөөд оршин буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ерөнхий захирал, ерөнхий нягтлан бодогч бусад албаны дарга нар болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



Асуудал 1: Мөнгөн хөрөнгийн талаар

**Тэргүүлэх ач
холбогдол №2**

Ажиглалт

Тус байгууллагад бэлэн мөнгөний кассын болон эд хөрөнгийн нярав байдаггүй. Нягтлан бодогч бэлэн мөнгөөр гүйлгээ хийж, анхан шатны баримтаар нягтлан бодох

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл

УСНББОУС, холбогдох хууль, заавар журамд нийцэхгүй байх

Зөвлөмж

1. Мөнгөн кассын болон эд хариуцагчийн ажил үүргийг нягтлан бодогчоос тусгаарлах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Багануур тоосго ТӨААТҮГ-ын хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



Асуудал 2: Нэгж бүтээгдэхүүний өртөг тооцох талаар

**Тэргүүлэх ач
холбогдол №2**

Ажиглалт

Тус үйлдвэрийн газар нь борлуулсан бүтээгдэхүүний өртгийг цех тасгууд дээр хуримтлуулан бүртгэдэг боловч үйлдвэрлэж буй нэгж бүтээгдэхүүн тус бүр дээр нарийн тооцож гаргаагүй байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжийн өртгийг зүй зохистой тодорхойлж чадахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-д “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”

гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүтээгдэхүүний нэгж өртгийг нарийвчлан тооцож байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэл

Тусгагдвал зохих зардал, өртөг нь санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх ба нэгж бүтээгдэхүүний борлуулах бөөний болон жижиглэнгийн үнэ бодитой бус байх.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 3: Төвлөрүүлэх шилжүүлгийн талаар

**Тэргүүлэх ач
холбогдол №2**

Ажиглалт

Тус үйлдвэрийн газар ШШГЕГ-т төвлөрүүлэн шилжүүлсэн 69.9 сая төгрөгийг тайлант жилийн үйл ажиллагааны бус зардлаар бүртгэж, тайлант жилийн алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь НББОУС-1-ийн 104-д “Аж ахуйн нэгж зардлыг чиг үүргээр нь ангилдаг бол...”, Сангийн сайдын 2014 оны 12 сарын 23-ны 249 тоот тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 6 дугаар бүлэгт “Зардал гэдэг нь тухайн тайлангийн хугацааны туршид байгууллагын үндсэн болон бусад үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотойгоор хөрөнгө буурах, өөр ямар нэг байдлаар ашиглагдах, эсвэл өр төлбөр нэмэгдэх байдлаар эдийн засгийн үр дүнг хорогдуулах ажил гүйлгээ үүсэх явдал юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл

Тусгагдвал зохих зардал, өртөг нь санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх.

Зөвлөмж

Зардлын ангиллыг өртгийг нарийвчлан тооцож байх

Төвлөрүүлэн шилжүүлж байгаа мөнгийг ногдол ашгаар бүртгэж байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Багануур тоосго ТӨААТҮГ-ын хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ

2017 оны 12-р сарын 31-ний байдлаар

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ҮЭ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12 сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,790,937.63	16,226,873.47
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		-
1.1.4	Бусад авлага	24,628,500.00	22,158,500.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	136,829,697.06	35,091,469.70
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	163,249,134.69	73,476,843.17
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	32,813,488.60	61,721,980.77
1.2.2	Биет бус хөрөнгө	3,285,619.72	1,980,748.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	36,099,108.32	63,702,728.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	199,348,243.01	137,179,571.94
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	5,410,250.00	10,603,117.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	4,126,122.36	1,064,764.85
2.1.1.4	НДШ-ийн өглөг	103,769.80	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,017,124.00	10,017,124.16
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө(борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	19,657,266.16	21,685,006.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	19,657,266.16	21,685,006.01
2.3	Үр өрөөл		
2.3.1	Өмч : - төрийн	192,291,669.83	192,291,669.83
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(12,600,692.98)	(76,797,103.90)
2.3.10	Тайлангийн үеийн		(64,196,410.92)
2.3.11	Өмнөх үеийн	(12,600,692.98)	(12,600,692.98)
2.3.12	Эзэмшигчдийн өмчийн дүн	179,690,976.85	115,494,565.93
2.4	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	199,348,243.01	137,179,571.94



АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ᠰᠢᠨᠬᠡᠭᠦᠭᠢᠨ	ᠠᠶᠢᠨᠣᠳᠤ	ᠣᠠᠡᠭᠡᠢᠨᠣ
1	Борлуулалтын орлого (цэвэр)	170,580,202.20	172,097,136.33
2	Борлуулалтын өртөг	117,062,598.82	147,559,608.54
3	Í èéò àø èā(àëäääääë)	53,517,603.38	24,537,527.79
4	Түрээсийн орлого	1,109,090.91	1,954,545.79
5	Хүүний орлого	52,535.81	96,556.76
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		4,435,001.80
10	Ерөнхий ба удирдлагын зардал	45,106,028.10	24,888,067.80
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал		-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	7,396,277.77	(61,440,876.41)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	16,969,479.77	(64,175,315.67)
19	Орлогын татварын зардал	297,448.41	21,094.95
20	Татварын дараах ашиг алдагдал	16,672,031.36	(64,196,410.62)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)	-	
24	Орлогын нийт дүн	16,672,031.36	(64,196,410.62)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ
1	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ		
1.1	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ (+)	172,782,511.57	146,498,167.00
	ᠪᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠪᠣᠷᠯᠠᠭᠤᠯᠤᠰᠠᠨ, ᠶᠢᠯᠠᠭᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ᠎ᠠ	4,386,500.00	125,155,050.00
	ᠠᠣᠯᠠᠭ᠎ᠠ ᠠᠨ ᠳᠡᠭᠡᠨ	168,396,011.57	21,343,117.00
1.2	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ (-)	168,818,804.36	128,158,787.92
	ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠳᠤᠳᠤ ᠲᠥᠯᠰᠡᠨ	71,864,294.51	52,272,360.61
	ᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	292,903.68	1,897,023.04
	ᠪᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠮᠠᠲᠣᠷᠢᠯ ᠬᠤᠳᠠᠯᠠᠨ ᠠᠶᠢᠬᠠᠳᠤ ᠲᠥᠯᠰᠡᠨ	38,610,670.00	13,566,600.00
	ᠠᠵᠤ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠵᠠᠳᠠᠶ᠋ᠠᠭ᠎ᠠ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	3,417,995.00	5,774,577.90
	ᠣᠵᠡᠭᠡ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ, ᠣᠵᠠᠳᠠᠶ᠋ᠠᠭ᠎ᠠ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ, ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	22,495,365.00	23,172,410.00
	ᠲᠠᠲᠠᠪᠠᠷᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠠᠭᠠᠳᠤ ᠲᠥᠯᠰᠡᠨ	12,932,626.17	24,338,415.10
	ᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ		
	ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭ᠎ᠠ	19,204,950.00	7,137,401.27
1.3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	3,963,707.21	18,339,379.08
2	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ		
2.1	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ (+)	52,535.81	96,556.76
	ᠶ᠋ᠨᠳᠠᠰᠠᠨ ᠬᠥᠷᠢᠩᠭᠡ ᠪᠣᠷᠯᠠᠭᠤᠯᠤᠰᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ᠎ᠠ		
	ᠪᠢᠡᠲᠤ ᠪᠤᠰᠤ ᠬᠥᠷᠢᠩᠭᠡ ᠪᠣᠷᠯᠠᠭᠤᠯᠤᠰᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ᠎ᠠ		
	ᠬᠦᠯᠡᠭᠢᠨ ᠠᠪᠰᠠᠨ ᠬᠦᠭᠦᠨᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ᠎ᠠ	52,535.81	96,556.76
	ᠬᠦᠯᠡᠭᠢᠨ ᠠᠪᠰᠠᠨ ᠨᠠᠭᠳᠣᠯ ᠠᠶᠢᠭᠢᠨ		
2.2	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ (-)	3,000,000.00	-
	ᠶ᠋ᠨᠳᠠᠰᠠᠨ ᠬᠥᠷᠢᠩᠭᠡ ᠣᠯᠵᠤ ᠺᠡᠮᠰᠢᠬᠡᠳᠤ ᠲᠥᠯᠰᠡᠨ		
	ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠣᠯᠭᠣᠰᠠᠨ ᠵᠡᠯᠤ ᠪᠣᠯᠠᠨ ᠤᠷᠦᠳᠠᠭᠢᠯᠠᠭ᠎ᠠ	3,000,000.00	
2.3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	(2,947,464.19)	96,556.76
3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ		
3.1	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ (+)	-	-
	ᠵᠡᠭᠡᠯᠤ ᠠᠪᠰᠠᠨ, ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠶ᠋ᠨᠡᠲᠤ ᠴᠠᠭᠤ ᠭᠠᠷᠭᠠᠰᠢᠨᠠᠭᠤ ᠬᠦᠯᠡᠭᠢᠨ ᠠᠪᠰᠠᠨ		
	ᠬᠤᠪᠠᠶᠠᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠶ᠋ᠨᠡᠲᠤ ᠴᠠᠭᠤ ᠭᠠᠷᠭᠠᠰᠢᠨᠠᠭᠤ ᠬᠦᠯᠡᠭᠢᠨ ᠠᠪᠰᠠᠨ		
	ᠲᠥᠷᠥᠯᠤ ᠪᠦᠷᠢᠶᠢᠨ ᠬᠠᠨᠳᠢᠪ	-	
	ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭ᠎ᠠ		
3.2	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ (-)	-	4,000,000.00
	ᠵᠡᠭᠡᠯᠤ, ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠶ᠋ᠨᠡᠲᠤ ᠴᠠᠭᠢᠨ ᠲᠥᠯᠪᠦᠷᠲᠤ ᠲᠥᠯᠰᠡᠨ ᠮᠣᠩᠭᠡ		4,000,000.00
	ᠪᠤᠰᠠᠳᠤ ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭ᠎ᠠ		-
3.3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠦᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	-	(4,000,000.00)
4	ᠠᠵᠤ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	1,016,243.02	14,435,935.84
5	ᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	774,694.61	1,790,937.63
6	ᠠᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ ᠠᠨ ᠶ᠋ᠢᠯᠠᠭᠢᠨ	1,790,937.63	16,226,873.47

01
 Төрийн Аудитын Байгууллага
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
БАГАНУУРТООСГОТӨААТҮГ

/төгрөгөөр/

	ᠰᠢᠰᠢᠭᠡᠭᠡᠳᠡ	Өмч	Халаасны хувьцаа	Í ýì æ ò° è° ääñ° í èäī èòàè	Хөрөнгийн дахин үеэᠶᠤᠰᠢᠭᠡᠳᠡ	Ääääää ääèp òù í 0° ðâᠰᠢᠭᠡᠳᠡ òèéí í°° ö	Эздийн өмчийн бусад хэсэг	Öóðèì òèäääñàí àø èä	Í èèò äᠵí
1	2015 í í û 12 ñàðû í 31-í ýýð᠔ ᠰᠢᠰᠢᠭᠡᠭᠡᠳᠡ	192,291,669.83						- 30,253,253.58	162,038,416.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							980,529.24	980,529.24
3	ᠰàèðóóèñàí ᠰᠢᠰᠢᠭᠡᠭᠡᠳᠡ								-
4	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал							16,672,031.36	16,672,031.36
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
9	2016 í í û 12 ñàðû í 31-í ýýð᠔ ᠰᠢᠰᠢᠭᠡᠭᠡᠳᠡ	192,291,669.83						(12,600,692.98)	179,690,976.85
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	ᠰàèðóóèñàí ᠰᠢᠰᠢᠭᠡᠭᠡᠳᠡ								-
12	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал							(64,196,410.92)	(64,196,410.92)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
	2017 í í û 12 ñàðû í 31 ° ä° ð	92,291,669.83						(76,797,103.90)	15,494,565.93

Бэлтгэсэн: Аудитор

М.Энхжаргал

Огноо:

2018 оны 03-р сарын 06-ны өдөр

